



## ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 08 сарын 23 өдөр

Дугаар А/171

Улаанбаатар хот


### Тушаалд өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Гаалийн тухай хуулийн 12.1 дэх хэсэг, 271<sup>1</sup> дүгээр зүйлийн 271<sup>1</sup>.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Захиргааны ерөнхий хуультай нийцүүлэх, Засгийн газрын 2018 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны 28 дугаар тэмдэглэлийг хэрэгжүүлэх зорилгоор Гаалийн ерөнхий газрын даргын 2008 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 735 дугаар тушаалын үндэслэх хэсэгт “Монгол Улсын Гаалийн тухай хуулийн 12.1 дэх хэсэг, Улсын гаалийн ерөнхий газрын Мэргэжлийн зөвлөлийн 2008 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь” гэж заасныг “Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Гаалийн тухай хуулийн 12.1 дэх хэсэг, 271<sup>1</sup> дүгээр зүйлийн 271<sup>1</sup>.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь” болгож өөрчилсүгэй.

2.Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Ц.Гэндэнцэвээн/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Б.АСРАЛТ

0001302